

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 04 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

а/ Сумын ИТХ-ын ажлын чиглэлээр: Төрийн болон Төрийн бус байгууллагуудын хамтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор “Аялах дэвтэр” ийг аялуулан энэ сард ЕБС хүлээлгэн өгсөн.

ГХУСАЗЗ-ийн ээлжит хуралдаан 2022 оны 03 сарын 22-ны өдрийн 14 цагт хуралдаж дараах асуудлыг хэлэлцэлээ.

1. 2022 оны ГХУСАЗЗ-ийн төлөвлөгөө батлах
2. Зөвлөлийн гишүүдийн саналыг сонсох, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцох

Мөн ИТХ-ын дарга байгууллагын дарга нартай уулзаж ИТХ-аас хийгдэж байгаа ажлын талаар мэдээ мэдээлэл өгч санал солилцон ажилласан.

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Монгол улсийн ерөнхий сайдын санаачлагаар зохион байгуулагдаж буй Илүүдэл жингүй эртэч Монгол аяны нээлтийг 2022 оны 04 дүгээр сарын 05 ны өдөр нээж нийт 5 албан байгууллагын 65 албан хаагч, 20 иргэд хамрагдлаа. Энэ хүү аяны хүрээнд албан байгууллага бүр нэг арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Долоо хоног бүрийн Даваа, Лхагва гариг бүр өглөөний 06:30 минутаас сумын ард иргэд, албан байгууллагын ажилтан албан хаагч нартай хамтран ажлын байрны дасгал хөдөлгөөнийг ЕБС зохион байгуулж ажиллаж байна. Мөн долоо хоног бүрийн мягмар, пүрэв гариг бүрийн өглөөний 06:30 цагт өглөөний алхалтыг ИТХ, оройны 18:00 цагт соёлын төв бүжгийн арга хэмжээнүүдийг тус тус тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар батлуулан ажиллалаа.

Засаг даргын ивээл дор “Оролцоод хөгжье” хүүхдийн чуулганыг 4 сарын 26 ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Чуулганаар хүүхдийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд тулгамдаж буй асуудлыг сумын удирдлагын түвшинд шийдвэрлүүлэх, мөн холбогдох хуулийн ойлголт өгөх хүүхдийн элчийг сонгон ажиллах юм.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:

4 дүгээр сард аймгаас санхүүгийн дэмжлэг ирээгүй, татварын орлогоос 18.7 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 60.1 сая төгрөг авч орон нутгийн төсвийн байгууллагуудад 78.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогоны сургалтанд 6 төсөвт байгууллага, 1 ОНӨҮГ 17 албан хаагчид хамрагдлаа.

Сумын нэгдсэн санхүүгийн тайлан аудитын байгууллагаас “Зөрчилгүй” дүгнэлт авсан

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн пүрэв гаригт цахимаар зохион байгуулагддаг сургалтад нийт 16 албан хаагчдыг хамруулж ажиллалаа.

ХАБЭА-н сарын аяны хүрээнд сумын хэмжээнд төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд ХАБЭА н чиглэлээр 2 албан хаагч баруун урт хотод зохион байгуулагдсан сургалтад хамрагдлаа.

Төрийн удирдлага мэдээллийн цахим сургалтад 4 сарын 21 ний өдөр тамгын дарга хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн нар хамрагдлаа.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Ерөнхий боловсролын сургууль: ХАБЭА-н сарын аяны хүрээнд төлөвлөгөө гарган ажиллаж 4-р сарын 23-ны өдөр “Аюулгүй байдал, эрүүл мэндийг төлөвшүүлье” өдөрлөгийг СӨБ тэй хамтран зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр багш сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, сургалтын хэрэглэгдэхүүн, үдийн цай болон дотуур байрын сурагчдын хоолны үзэсгэлэн, ажлын байрны дасгал хөдөлгөөн, багш сурагчдын дүрэмт хувцасны үзүүлбэр зэргийг эцэг эх ард иргэдэд үзүүлж сонирхуулсан. Өдөрлөгт нийт 113 эцэг эх хамрагдсан. Мөн ХАБЭА-н аяны хүрээнд төлөвлөгөөний дагуу сургуулийн захирлын тушаалаар томилогдсон эрсдлийн үнэлгээний баг сургуулийн гадна болон дотор орчинд эрсдлийн үнэлгээг хийсэн.

ИТХ-аас Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын үйл ажиллагааг сайжруулах аяны хүрээд эцэг эхчүүдийн дунд Спортын 3 төрөлт тэмцээн, сумын нэгдсэн хог цэвэрлэгээ зэргийг зохион байгуулсан.

Сайн багшийн сайн технологи ур чадварын уралдааны 1-р шатыг амжилттай зохион байгуулж шалгарсан багш нар дараагийн шатанд оролцохоор бэлтгэлээ ханган ажиллаж байна.

Эко клубын сурагчид “ Эх дэлхийн өдрийг угтан” сургуулийн гадна орчин, тоглоомын талбайг цэвэрлэсэн.

Дэлхийн номын өдөрт зориулан сурагчдын болон насанд хүрэгчдийн хүсэл сонирхолд нийцсэн шинэ номын үзэсгэлэнг гаргасан.

Соёлын чиглэлээр: 5 дугаар сарын 5 нд ны өдөр баруун урт хотод зохион байгуулагдах урлагын наадамд ажлын хэсэг байгуулан бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн төв нь 4 дүгээр сард батлагдсан тохиолдол гараагүй байна. Нийт кластери 78 бүгд хаагдсан. Гэрийн эмчилгээнд хүн байхгүй Ойрын хавьтал байхгүй байна. Ковидийн рсг ийн шинжилгээнд иргэн хамрагдаагүй . Түргэвчилсэн шинжилгээг 5 иргэнд хийсэн. бүгд сөрөг байсан.

Ковидийн 4 тунд 9 иргэн хамрагдсан. В вирусийн шинжилгээнд 32 хамрагдсан В вирусийн 1 тун вакцин 60 хүнд хийсэн 2 тунг 4 хүнд хийсэн

Насанд хүрэгчдийн болон 0-18 насны эрт илрүүлгийн үзлэг ажлын бэлтгэл ажилд Эрүүл мэндийн газарт хоёр их эмч болон нийгмийн эрүүл мэндийн ажилтан нар 2022 оны 04 сарын 18 наас 4 хоногийн сургалтанд хамрагдсан.

Мөн бүх иргэдийг эрүүл мэндийн даатгалтай, даатгалгүй судалгааг гаргаж эрүүл мэндийн газарт нэрсийг нь гарган явуулсан.

Хөдөлмөр халамжийн чиглэлээр: 2022 онд Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн зарлан төсөл хөтөлбөрт хамрагдах иргийн төслийг хүлээн авч одоогоор Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 4 төсөл, Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 4 төсөл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2 төсөл, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн төсөлд 1 төсөл ирсэн байна.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар байнгын асаргааны 2 иргэний асаргааны сунгалт, 2022 онд хөгжүүлэх өрх, дэмжлэг үзүүлэх өрхийг баталсан.

Мал эмнэлэгийн чиглэлээр: 2022 оны 04 сарын 07, 08 ний өдрүүдэд СҮХБААТАР АЙМГИЙН МАЛЫН ЭМЧ, МЭРГЭЖИЛТЭН НАРЫН НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨН-2022 2 хоног зохион байгуулагдаж, Зөвлөгөөнд аймгийн Засаг даргын орлогч дарга, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг, аймгийн МЭГ, 13 сумын мал эмнэлгийн тасаг, хилийн цэргийн 2 отряд, 56 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн нийт 110 малын эмч, алба хаагчид оролцож мэдээлэл солилцсон.

Мал, амьтны гоц халдварт өвчний талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын онцгой комиссын 02 тоот тогтоол, МЭЕГ-ын даргын А/77 дугаар тушаалын дагуу “Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын аян”-ыг албан ёсоор эхлүүллээ. Аяны нээлтийн хүрээнд сумдын Улсын байцаагч, Тархвар зүйчдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, вакциныг кодлон, халдваргүйтгэлийн бодис, ХХ-ын хувцас, вакцины хөргүүр, автомакс зэргийг МЭГ-ын нөөцөөс хувиарлан өгсөн.

Сумын хэмжээнд 28,4 л вакцин татан авч аж ахуй нэгжийн тамганы 4 оронгоор кодлон 5 грүүнд хувиар хийсэн. Тарилга хийхэд шаардагдах бензин, зүү шпризны зардлыг сумын гамшигаас хамгаалах зардлаас гаргасан. 102 өрхийн 7394 мал хамрагдаад байна.

Шүлхий өвчний 1 голомтын 3 өрхийн 11402 мкв талбайд эцсийн ариутгал хийж хязгаарлалтын дэглэм цуцлагдсан.

Шинээр 1 голомтод хорио цээрийн дэглэм тогтоож 14425 мкв талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн.

Байгаль орчны чиглэлээр: “Цэвэр орчин- Тохилог хашаа” хөтөлбөрийг боловсруулан батлуулав.

Нийтийн эзэмшлийн гудамж талбай цэвэрлэх хуваарь гарган Засаг даргаар батлуулан албан газрын дарга эрхлэгч нарт танилцуулав. Хог хаягдлын хураамжийг тог цахилгааны төлбөртэй хамтатган төвлөрүүлэх талаар ДБЭХСТӨХК-ны Сүхбаатар аймаг дахь салбарын даргад сумын Засаг даргын 2022 оны 04 сарын 19-ны өдрийн 1/45 тоот албан бичгээр хүсэлтийг гарган хүргүүлэв.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар гаргасан аймгийн Засаг даргын
01 тоот албан даалгаварын биелэлтийг гарган аймгийн ОБГ-т хүргүүлэв.

ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА: М.БАТБЭХ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Д.ДАЙРИЙМАА